

“Үлгэрийн далай” сударт зөв амьдрах тухай сургасан нь

Доржсүрэнгийн БҮРНЭЭ*

Монгол улс, Улаанбаатар,
Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх Ухааны Сургууль,
Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

Received: Aug 23, 2024

Revised: Sep 7, 2024

Accepted: Oct 25, 2024

Хураангуй: Буддын шашины ёс зүйн талаар сүүлийн үед гадаад, дотоодод их бичих болжээ. Манай орны тухайд эрт дээр үеэс уламжлагдан ирсэн буддын шашины хөлгөн судруудад, бурхан багшийн зарлиг сургаалд бие, хэл, сэтгэлийн аливаа үйлийг чанд сахих тухай үзэл санаа бүрэн дүүрэн туссан байх учир хүн ард түүнийг шүтэн бишрэх төдийгүй амьдрал ахуйдаа даган мөрдөж ирсэн түүхтэй. Буддын шашины ёс зүйн талаар бичсэн ийм судрын нэг бол “Үлгэрийн далай” бөгөөд тус сударт хутагтын найман мөрийн нэг болох зөв амьдрах тухай өгүүлсэн нь шашин номын гүн гүнзгий утгатай төдийгүй Бурхан Буддагийн айлдсан дөрвөн үнэн, үйлийн үрийн тухай сургаал, бие, хэл, сэтгэлээ сахих тухай арван цагаан буян, арван хар нүглийн тухай сургаалтай нягт холбогдоно.

Түлхүүр үг: “Үлгэрийн далай”, дөрвөн үнэн, хутагтын найман мөр, зөв амьдрал, үйлийн үр

Teaching of Right Livelihood in the Sutra Üliger-ün Dalai

BURNEE Dorjsuren

Department of Mongolian Language and Linguistics
NUM, School of Science
Ulaanbaatar, Mongolia

Abstract: In recent years, substantial scholarly attention has been devoted to Buddhist ethics on a global scale. Among the vast corpus of Buddhist literature, many sutras from antiquity encapsulate the Buddha's teachings on virtuous actions of body, speech, and mind. These teachings have been adopted by Mongolian practitioners and integrated into their daily lives. One such significant text is the Üliger-ün Dalai

* © Д.Бүрнээ 2024

Email: burneedorjsuren@gmail.com

(mDo mdzangs blun), a Buddhist ethical sutra that highlights the concept of Right Livelihood, a key component of the Noble Eightfold Path. This teaching is deeply interconnected with the Buddha's doctrine of the Four Noble Truths and the karmic law of cause and effect, forming a foundational aspect of Buddhist practice and ethical living.

Key words: *Üliger-ün Dalai, Four Noble Truth, Right Livelihood, the karmic law of cause and effect*

1. Удиртгал

Буддын шашин манай эриний өмнөх VI-V зуунд Энэтхэг оронд үүсэн хөгжиж, улмаар Энэтхэгээс халин гарч, Дундад, Төв, Зүүн хойд Азийн улс орнуудад түгэн дэлгэрсэн түүхтэй. Буддын шашин гэдэг ойлголтод дан ганц шашин гэдэг ухагдахуунаас гадна Энэтхэг болон Азийн янз бүрийн улс орны соёл, мэдлэг ухааны их өв санг хамарсан өргөн ойлголт багтдаг. Буддын шашин Монгол орноо гурван удаа дэлгэрсэн бөгөөд нийт хоёр мянга гаруй жилийн түүхтэй гэж үздэг. XVI зууны гурав дахь, төвөдийн шарын шашны дэлгэрлийн үед буддын шашин манай ард түмний аж амьдрал, ахуй соёлд өргөн далайцтай нэвтэрч, бүх нийтийг хамарсан шүтлэг болж, хэл соёл, зан заншил, сэтгэлгээнд нэвт шингэж, гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн билээ. Буддын шашин бол хүний дотоод чадавхыг хөгжүүлж, ертөнцийн уг чанарыг ухааруулж, нигүүлсэн амарлихын их сэтгэлд хүргэхийг гол зорилтоо болгох учир оюун сэтгэхүйг төгөлдөржүүлэх, сэтгэлийг ариусгахад чиглэсэн хүний тухай ухаан болно (Лувсанцэрэн, 2019: 212). Буддын шашны онол сургаал бурхан Буддагийн айлдсан зарлиг сургаалд тусгалаа олж, дэлхийн улс ард олон зууны туршид түүнийг шүтэн биширч иржээ. Монголчуудын дунд дэлгэрч, нийт ард түмний хүртээмж болсон дурсгал бол энэтхэгийн хэлээр “Даммамука”, төвөд хэлээр “Дозанлүн”⁷² буюу “Цэцэн тэнэгийн судар” хэмээх дурсгал бөгөөд тус зохиолын дөрвөн зүйлийн монгол орчуулга уламжлан ирсэн нь Ширээт гүүш цорж, Цүлтимлодой, Тойн гүүш, ойрадын Зая бандида Намхайжамц нарын орчуулга болно (Бүрнээ, 2003: 35-83). Эдгээр орчуулгаас Ширээт гүүш цоржийн “Шулуун онолт” хэмээх орчуулга олон зүйлийн гар бичмэл, хятад болон буриад бар төдийгүй монгол Ганжуурын 90 дүгээр ботид орсон байхаас гадна нийт ардын дунд “Үлгэрийн далай” хэмээх нэрээр алдаршжээ. Тус судар нь Бурхан багшийн хамаг амьтныг энэрч нигүүлсэн, асарч тэтгэсэн, аливаа зовлон гачаалаас авран тэтгэсэн, бие, сэтгэлээ ариусган гэгээрэлд хүрсэн их үйлсийг нийт хүн ардад үлгэр дуурайл, жишиг хэмжүүр болохуйц өгүүлсэн учраас тийнхүү “Үлгэрийн далай” хэмээн нэрийдсэн бололтой. Ширээт гүүш цоржийн орчуулсан “Шулуун онолт” судар 52 бүлэгтэй, харин төвөд “Дозанлүн”

⁷² mdzangs blun zhes bya ba'i mdo

51 бүлэгтэй байх бөгөөд Их Хүрээнд бартай 52 бүлэгтэй төвөд “Дозанлүн” судар бол 51 бүлэгтэй төвөд сударт байдаггүй “Хан хөвгүүн Сошдай”-н бүлгийг Ширээт гүүш цоржийн орчуулгын 7 дугаар зүйлээс авч 52 дугаарт оруулсан төвөд эх болно. Ширээт гүүш цоржийн орчуулгын төвөд эх судар одоогоор олдохгүй байгаа бөгөөд монголчууд энэхүү 52 бүлэгтэй судраа төвөд “Дозанлүн” судраас ялгаж, монгол “Үлгэрийн далай” гэж нэрлэж иржээ. Үүний нэг баримт бол Арвайн хошууны захирагч Аюушийн XIX зууны үед 52 бүлэгтэй “Үлгэрийн далай” судрын агуулгыг товчлон найруулсан “Mongᠭol-un üliger-ün dalai kemegdekü sudur-un qurᠭiangᠭui” хэмээх судар болно (Ганзаяа., Мөнхсамбуу, 2015).

2. Судалгааны хэсэг

“Үлгэрийн далай” бол буддын шашны утга зохиолын цадиг хэмээх төрөл зүйлд багтах бөгөөд түүнд бурхан Буддагийн урьд насны намтар түүхийг өгүүлсэн байх бөгөөд цадигийн зохиомж нь асуулт хариултын журмаар өрнөж, шавь Анандын зүгээс сонирхсон зүйлийн талаар асуухад бурхан бээр учир явдлыг дэлгэрэнгүй өгүүлэхдээ тухайн цаг үед болсон аливаа сайн, муу үйл явдал нь урд насны үйлийн үр дагавар болохыг тайлбарлан таниулна.

Буддын шашны цадиг бүр зөв амьдрах тухай үзэл санааг агуулсан байх бөгөөд хутагтын найман мөр, дөрвөн үнэний тухай сургаалтай нягт уялдан холбогдоно. Хутагтын найман мөр нь үнэн үзэл⁷³, үнэн онол⁷⁴, үнэн үг⁷⁵, үнэн үйл⁷⁶, үнэн амьдрал⁷⁷, үнэн хичээл⁷⁸, үнэн дуртгал⁷⁹, үнэн бясалгал⁸⁰ юм. Дөрвөн үнэн⁸¹ нь зовлон үнэн⁸², бүхэн гарахуй үнэн⁸³, түрдэхүй үнэн⁸⁴, мөрийн үнэн⁸⁵ болно. Дөрвөн үнэний сургаалын тус эрдмийн талаар “Үлгэрийн далай”-д хэрхэн өгүүлснийг авч үзье. “Тэндээс (Бурхан багш) дөрвөн үнэний номуудыг дэлгэрэнгүйгээ үзүүлсэнд сэтгэл нь маш тонилоод хамаг цувралыг барж архад болов”, “дөрвөн үнэнийг дэлгэрэнгүйгээ үзүүлсэнд бие, хэл, сэтгэлийн үйл маш арилаад, сэтгэлийн хир арилж бүрүүн. Зарим нь үргэлжид орсон ба нэгэнт харин ирэгч ба харин үл ирэгч ба дайныг дарсны хутгийг олов. Зарим нь дээргүй үнэн төгс туулсан бодь хутагт сэтгэл үүсгэв (Шижир бярмань дөчин нэгдүгээр

⁷³ тө. yan dag pa'i lta ba

⁷⁴ тө. yan dag pa'i rtogs pa

⁷⁵ тө. yan dag pa'i ngag

⁷⁶ тө. yan dag pa'i mtha'

⁷⁷ тө. yan dag pa'i 'tsho ba

⁷⁸ тө. yan dag pa'i rtsol ba

⁷⁹ тө. yan dag pa'i drag pa

⁸⁰ тө. yan dag pa'i ting nge 'dzin

⁸¹ тө. bden pa bzhi

⁸² тө. sdug bsngal bden pa

⁸³ тө. kun 'byung bden pa

⁸⁴ тө. 'gog bden

⁸⁵ тө. lam bden

зүйл), “дөрвөн үнэний номыг үзүүлснээр сэтгэлийн хир нүгүүд огоот арилаад дайныг дарсны хутгийг олов (Данжила нэрт гэрийн эзний дөчин хоёрдугаар зүйл) гэжээ. Дөрвөн үнэний сургаалын утга учрыг ойлгож ухаарах нь зовлонгийн учир шалтгааныг олж, түүнээс ангижрах арга замыг олох, улмаар бие, хэл, сэтгэлийн гэмийг арилгаж, гэгээрэлд хүрэх явдал юм хэмээн өгүүлснийг бид дээрх жишээнээс харж байна. Нөгөөтгээгүүр, цадигийн үйл явдал бас дөрвөн үнэний сургаалыг ухааруулна. Тухайлбал, “Удвал нэрт шамнанцын хорин зургаадугаар зүйл”-д Удвал хэмээх эмэгтэй чинээлэг гэрт төрж өссөн нэгэн бөгөөд эр нөхөрт гарч хоёр хүүхэд төрүүлдэг. Удалгүй хадмууд нь нас нөгчсөн тул төрсөн гэртээ очихоор эр нөхөр, үр хүүхдийн хамт замд гарч явтал, эр нөхөр нь зам зуур унтаж байхдаа хорт могойд хатгуулж амиа алдахад Удвал бүсгүй гашуудан зовж, арга буюу хоёр хүүхдээ авч цааш явна. Зам зуурт нь ширүүн урсгалт гол тааралдаж, гол гатлахын тулд арга буюу нэг хүүхдээ орхиод, нөгөө хүүхдээ голын цаад эрэг дээр хүргээд буцах хооронд хүүхэд нь бага балчир учраас эхийнхээ хойноос ороод усанд урсан оджээ. Харин өмнө орхисон хүүхдийг нь чоно идсэн байх учир орь ганцаар болж эмгэнэн гашуудаж, төрсөн гэр орондоо очих гэтэл эцэг эхийнх нь гэр галд автаж, эцэг эх нь амиа алдсан байв. Зовж зүдэрсэн бүсгүй дахин эр нөхөрт гарсан ч урдхаас үлэмж их зовж буй энэ түүх бол бурхан багшийн айлдсан дөрвөн үнэний нэг болох зовлон үнэн хэмээх сургаалын нэгэн жишээ болно. Удвал бүсгүй зовлонгоос гэтлэхийн тулд хутагтын найман мөрийн нэг тулгуур үзэл болох үнэн үзлийг баримталж, буддын шашны шамнанцын сахилыг сахиж, улмаар зовлонгоос ангижраад зогсохгүй гэгээрэх зам мөрт орж буй тухай өгүүлнэ.

Хутагтын найман мөрийн тухай сургаалын доторх үнэн амьдрал буюу зөв амьдралын тухай үзэл санаа нь бусад долоон үзэлтэйгээ нягт холбоотой. Өөрөөр хэлбэл, зөв амьдрахын тулд зөв онол үзлийг дагаж мөрдөх, зөв ярьж, зөв үйл хийх, цаашлаад зөв хичээл шамдал, бясалгал хийх учиртай байна. Зөв үзэл, зөв онол нь үнэн бодол сэтгэлээр илрэх бөгөөд “Үлгэрийн далай”-д атгаг сэтгэлийг тэвчих тухайд “урин сэтгэлээ амарлиулах”, “өст сэтгэлгүй болох”, “гэмших сэтгэлийг төрүүлэх”, “харам, найдангүй (*атаархах сэтгэл* Д.Б) сэтгэлийг тэвчих”, “сэтгэлийн хирийг арилгах”, “тачаангүй сэтгэлийг барах” зэрэг сэтгэлийн гэмийг арилгахын сацуу ерөөс бие, хэл, сэтгэл гурав нягт холбоотой учраас “бие, хэл, сэтгэлээ сахиж арван буянд орших”, “бие, хэл, сэтгэлээ бэхлээд, дээд буяны зүгт хичээх”, “хамаг бүгд бие, хэл, сэтгэлээр буяныг зорих”, “бие хэл сэтгэлийн үүднээс буяны зүгт хичээх”, “бие, хэл, сэтгэлийн үйлсийг сахин хичээх”-ийн ач тус, эс хичээсний хор уршгийг олон үлгэр цадигийн жишээгээр харуулжээ. Аливаа зөв үйлийн эхлэл болох зөв үзэл, зөв онолыг төлөвшүүлэхийн эцсийн зорилго бол “бодь хутагт сэтгэл үүсгэх”, “дээргүй бодь сэтгэл үүсгэх”, “чин бат сэтгэлээр бурханы хутгийг олох” явдал

бөгөөд үүний тулд “маш үнэн чин сүсэг сэтгэлт болох”, “асрах сэтгэлийг бясалгах”, “нигүүлсэхүй сэтгэлт болох”, “бие сэтгэлээ тэгш агуулж, нэгэн үзүүрт сэтгэлээр” бясалгах, “номыг нэгэн үзүүрт сэтгэлээр чанд бясалгах” зэрэг сэтгэлийн олон зөв үйл хийхийг чухалчилсан байна. Тухайлбал:

Асрахуй сэтгэлийг бясалгагтун
Урин хилэнт сэтгэлийг тэвчигтүн
Их нигүүлсэхүйгээр амьтныг ивээгтүн
Хотол хамгийг нигүүлсэхүйгээр өршөөгтүн
Их баясгаланг бясалгагтун
Бусдыг бээр өөр лүгээ найралдах ном
Бодьчид сэтгэлээр аварваас л

Бодисадва нарын явдал буюу хүү (Элдэв үлгэрийг үзүүлсэн тэргүүн зүйл) хэмээн өгүүлсэн нь бодисадвын зам мөрөөр замнахад сэтгэлээ шинжиж, сэтгэлийн гэмийг танин мэдэж арилгах, өршөөл хайрыг бясалгахын учир зорилгыг өгүүлжээ. Түүнчлэн ертөнцийн юм үзэгдэл мөнх бус болохыг сургаж,

Хамаг хураасан бүгд барагдьюу
Өндөр болсон тэр бээр эцэст унаюу
Хурах буй л бөгөөс хагацах больюу

Төрөх буй л бөгөөс үхэх больюу (Элдэв үлгэрийг үзүүлсэн тэргүүн зүйл) хэмээн бичсэн нь аливаа үйлд эхлэл байдгийн нэгэн адил төгсгөл байдаг, өөдөлж өгсөж явахын сацуу буурах доройтох цаг ирдэг, хэдий чинээ хөрөнгөтэй, төгс төгөлдөр, эрдэм боловсролтой байсан ч ертөнцийн мөнх бусыг үзүүлэх цаг хүн бүхэнд алагчлалгүй ирдэг гэдгийг сануулж, хийж буй аливаа үйлийн үр боловсрол, хэтийн хөгжил буурлыг бодон санаж, ухаалаг зөв амьдрахыг сануулсан байна.

Үнэн амьдрал буюу зөв амьдралын тухай сургаал зөв үйлтэй нягт холбоотой. Зөв үйлийг бие, хэл, сэтгэлээр үйлдэх арван сайн үйл гэж авч үзвэл эдгээр нь арван хар үйлийн ерөндөг болох билээ. Эдгээрээс биеэр үйлдэх гурван сайн үйл нь бусдын амийг аврах, өглөг өгөх, ёс журмыг сахих явдал юм. Хэлээр үйлдэх сайн үйлд үнэн ярих, найртай үг хэлэх, бага ярих, зөөлөн ярих явдал орно. Харин сэтгэлээр үйлдэх сайн үйлд асрах сэтгэл, өргөх сэтгэл, үнэн үзэл багтана хэмээн арван хар нүглийн дарлага болох арван цагаан үйлийг багтаан ойлгож болох юм. “Үлгэрийн далай”-д сайн болон муу үйлийн үр дагаврыг тодорхой харуулсан олон цадиг бий. Тухайлбал: “Очир нэрт охин”-ы зүйлд чинээлэг язгууртны гэрт төрсөн боловч төрөлхийн үзэшгүй муу зүстэй төрснөөс болж ихээхэн зовон шаналж буй Очир охин нь урд насандаа бурсан хуврагийг үзэшгүй муу зүстэй хэмээн жигшин доромжилсон учир тийнхүү муухай царайтай төржээ. Харин гэмээ ухаарч наманчилсны учир хөрөнгө чинээлэг язгууртны гэрт төрсөн байна. Түүнчлэн дээр өгүүлсэн Удвал нэрт бүсгүй ямар учир шалтгаанаар тийнхүү их зовсны учир шалтгаан бол урд

насандaa өөрийн төрсөн үрийг өв залгамжлуулахын тулд өөр эхнэрийн үрийн зулайг тэвнээр хатгаж хороосон нүгэлт үйл хийсэн явдлаас үүдэлтэй ажээ. Энэ мэт “Үлгэрийн далай”-д зөв үйл хийхийн ач тусыг ухааруулсан олон цадиг байхаас гадна буддын шашны гүн гүнзгий утга агуулгыг адилтгал зүйрлэлийг ашиглан тайлбарласан байна. Тухайлбал: “Тачаангуй нь галд адил болоод, хамаг уул гол түлэгднө. Өвсөнд адил бөгөөд улам улам нэмж түлэгдмүй. Тачаангуйн эрхээр хөнөөж, нэгэн нэгэндээ хор хүргэснээр гурван муу заяанд унаад, тонилох эрхгүй болъюу” (Удвал шамнанцын хорин зургаадугаар зүйл) хэмээн шунан тачаах хомхой сэтгэлийг галтай зүйрлэж, галд өртөж түлэгдэхгүй зүйл байхгүйтэй нэгэн адил нэр алдар, хөрөнгө мөнгөнд хөтлөгдсөн шунахай сэтгэлийнхээ уршгаар хүн төрөлхтөн хэдэн үеийн туршид зовон зүдэрч, адгуус, бирд, тамын гурван муу заяаны төрлөөс гэтэлж чадахгүй, улмаар сансрын хүлээснээс гарч чадахгүй зовдгийг энгийн ойлгомжтой тайлбарлажээ. Түүнчлэн “үзүүлсэн ном минь маш ариун бөгөөд овог язгуур ба баян үгээгүй ялгалгүй бүлгээ. Үлгэрлэвээс, тунгалаг усаар угааваас овог язгуур ба баян үгээгүй ба сайн муу бүгдээрийг ялгалгүй арилгахад адил болой” (Эедэгч гэрийн эзний гучин тавдугаар зүйл) гэсэн нь бурханы зарлиг сургаалыг хир буртгийг арилгаж ариусгах ариун устай зүйрлэж, бурханы сургаал дээд доод, баян ядуу, ухаантай ухаангүй хэнийг ч болов ялгалгүй аварч нигүүлсэх учир зорилготой байдагтай харьцуулан тайлбарлажээ.

Түүнчлэн энэ насны утга учир бол бие, хэл, сэтгэлээ сахиж хутагтын найман мөрөөр замнах явдал бөгөөд энэ насны явдлыг хичээснээр дараа төрлийн үйл сайн буюу муу байхын үүтгэл болно гээд “энэ төрөлд би хойт төрлийн үйлийг эс үүсгэвээс магад зовох болмуй за. Үлгэрлэвээс тариач хүн хавар эс тариваас намарт авахгүйд адил, би бээр энэ төрөлд хавар эс цацваас хойд төрлийн намарт авах үгүйн тулд эдүгээ би зальхалзваас үл болмуй” (Нүдэн нээсэн хааны гучин зургаадугаар зүйл) гэжээ. Өөрөөр хэлбэл, тариачин хүн хавар сайн үр хөрөнгө суулгаж байж намар нь сайн ургац авахтай адил энэ насандаа алгуурлаж, бие хэл сэтгэлээ сайтар сахиж чадахгүй бол алс хэт нь цаглашгүй их зовлонгийн үүд хаалгыг эцэс төгсгөлгүй татах болно хэмээн тайлбарласан байна.


3. Дүгнэлт

Ийнхүү төвөд, монгол, орос, англи, герман зэрэг дэлхийн олон хэлнээ орчуулагдсан, монголчуудын дээдлэн шүтэж ирсэн “Үлгэрийн далай” нэрт хөлгөн сударт энэ хорвоод аливаа юм үзэгдэл хоорондоо нарийн нягт холбоо хамааралтай буюу шүтэн барилдлагатай, холбоо хамааралгүй ямар ч зүйл байхгүй, аливаа зүйлийг нэг талаас нь, нэг өнцгөөс нь бус, харилцаа холбоонд нь харж байх тухай, хүний амьдралын эцсийн зорилго бол бусдыг энэрч нигүүлсэж, аварч тэтгэх, бие, хэл, сэтгэлээ ариусгаж гэгээрэлд хүрэх явдал

хэмээн сургажээ. Бурхан Буддын айлдсан дөрвөн үнэн, хутагтын найман мөр, үйлийн үрийн тухай сургаалын үзэл санаа нь “Үлгэрийн далай” судрын цадиг бүрт гүн гүнзгийн шингэж, одоо, өнгөрсөн, ирээдүйн гурван цагт уягдахгүй, хол ойрын орон зайд хүлэгдэхгүй хүн төрөлхтний зөв амьдрах хөтөлбөр болсоор байгаа билээ.

Ном зүй

- Бүрнээ, Д.** (2022). Буддын шашин соёлын холбоотой үг хэллэг, нэр томъёог орчуулах асуудалд, *Орчуулга зүй*, № 10 (571), Удам соёл хэвлэх үйлдвэр.
- Бүрнээ, Д.** (2003). “Үлгэрийн далай”-г хэл шинжлэлийн үүднээс харьцуулах нь //Бүрнээ Д, Энхтөр Д. *Уламжлалт орчуулгын судлалд*, Цээл-Эрдэнэ хэвлэх үйлдвэр, х.1-176.
- Лувсанцэрэн, Г.** (2019). *Буддын гүн ухааны сэтгэлгээ, Буддын гүн ухааны онол, түүхийн асуудлаас, төв үзэл төвшин бодлого, бүтээл туурвилын эмхэтгэл*. Бемби сан хэвлэлийн газар.
- Бүрнээ, Д., Энхтөр, Д.** (2023). *Үлгэрийн далай*. Худам монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлэн оршил, тайлбар бичсэн Д.Бүрнээ, Д.Энхтөр, Удам соёл хэвлэх үйлдвэр.
- Парфионовича, Ю.М.** (1978). *Сутра о мудрости и глупости* (Дзанлундо). перевод с тибетского, введение и комментарий Ю.М.Парфионовича, издательство “Наука”. [Үлгэрийн далай. Төвөд хэлнээс орчуулж, оршил бичсэн Ю.М. Парфионович. 1978]
- Schmidt, I.J.** (1978). *Der Weise und der Thor*. aus dem Tibetischen übersetzt von I.J.Schmidt. Gustav Kiepenheuer Verlag.
- mDzangs blun zhes bya ba'i mdo. (1984). mtsho sngon mi rigs dpe skrun khang. [Үлгэрийн далай хэмээх оршвой. 1984. Хөх нуурын Ардын хэвлэлийн хороо]
- Ганзаяа, Я., Мөнхсамбуу, А.** (2015). *Mongyol-un üliger-ün dalai kemegdekü sudur-un quriyangni*. Өвгөн захирагч Аюушийн бичсэн үлгэрийн далайн товчлол, монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлж тайлбар бичсэн Я.Ганзаяа, А.Мөнхсамбуу, “Мөнхийн үсэг” ХХК-д хэвлэв.
- Stanley Frey.** (1981). *Sutra of the Wise and the Foolish (Mdo mdzangs blun) or the ocean of narratives (Üliger-ün dalai)*. translated from the Mongolian by Stanley Frey, New Delhi.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.